

ХИ АНГИЙН ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН БИЕ ДААН СУРАЛЦАХ АЖЛЫН ДЭВТЭР

Сурагчийн овог, нэр _____	Эхэлсэн он.... сар....өдөр.... цаг Дууссан он.... сар.... өдөр.... цаг
---------------------------	---

БҮЛЭГ СЭДЭВ: 1924-1990 оны БНМАУ-ын нийгэм, эдийн засаг, улс төрийн байдал

АГУУЛГЫН ХУРААНГУЙ

1921 оны хувьсгал Монгол Улсыг дэлхийн түүхийн тавцанаа дахин гаргах сайн цагийн эхлэл болсон юм. Гэвч Монголын газар зүйн байршлийн стратегийн ач холбогдлоос үүдэн Зөвлөлт Холбоот Улс болон Коминтерн манай улсын нийгэм, улс төрийн амьдралд нэн хүчтэй нөлөөлөх болсноор капиталист бус хөгжлийн зам хэмээх социалист чиг баримжаат төр засгийн байгууламжийг МАН-ын III Их хурлаас байгуулахаа зарлаж 1924 оны анхдугаар Үндсэн хуулиар баталгаажуулав. 1921-1940 –д он хүртэлх хугацаанд хөгжлийн капиталист бус замналаар замнах эерэг, сөрөг үр дагавар бүхий бодлогууд хэрэгжив. Мөн Зүүнтний улс төрийн чиг бодлогыг эсэргүүцсэн дүрвэн нүүх хөдөлгөөн, бослого, улс төрийн хэлмэгдүүлэлт, халх голын байлдаанд ялалт байгуулсан түүх энэ үед болж өнгөрсөн юм.


1940 оны МАХН-ын X их хурал, Улсын VIII их хурал тус тус хуралдаж, зөвлөлтийн заавраар нийгэм журам буюу социализмд шилжих бэлтгэлийг хангах зорилтыг дэвшүүлэн тавьж, үүнийгээ Үндсэн хуулиар баталгаажуулав. Дэлхийн II дайны сүүлээр их гүрнүүд Ялтын бага хурлаар Гадаад Монголыг статус квог хэвээр байлгахад тогтсон нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх гол шижим болсон билээ. Дайны дараа улс орон социализмыг бүтээн байгуулахын тулд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагт шилжжээ. Энэхүү бүтээн байгуулалт Монголд нийгэм, эдийн засаг, соёлын асар их өөрчлөлтийг авчирч байв. Ардын хувийн аж ахуйтныг хоршооллож, хувийн өмчийг устган, атар газар эзэмшиж, газар тариалан хөдөө аж ахуйн бие даасан салбар болов. 1950-иад оны эхэн, түүний дараах үед ч гэсэн нэг хүнийг тахин шүтэх явдал газар авч, улс төрийн удирдагч нараас өөр үзэл бодолтой сэхээтнүүдийг хавчин шахаж, нухчин дарж байв. Эдийн засгийн хувьд улсын ба хоршооллын нийгмийн өмч ноёрхох болов. Энэ үед нийгмийн бүтцийг ажилчин анги, хоршоолсон ард, хөдөлмөрийн сэхээтэн гэсэн гурвалаар хязгаарлаж, нийгмийн бүтцийг бусад бүрдлийг үл тоомсорлож байлаа. Оюун санааны хувьд, олон ургальч үзлийг хааж боож, нийгмийн оюун санаа хэт үзэл сурталжиж, марксизм-ленинизмыг цорын ганц үнэн зөв сургаал хэмээн тунхаглаж байв.

Гадаад бодлогын хувьд, БНМАУ 1961 онд НҮБ-ын гишүүн болж, БНМАУ дэлхийн хамтын нийгэмлэгт зүй ёсны байр сууриа эзэлсэн юм.

Ашигласан материал: *Дэлгэржаргал, П, Чинзориг, Б, Болдбаатар, Б. (ред) МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ. Улаанбаатар 2017, МУИС ПРЕСС*

1. Дасгал, даалгавар

А. Түлхүүр ойлголтуудыг зөв тохируулна уу?



- | | |
|----------------------|---|
| 1. Коминтерн | a) Хаант орос улсын үед дангаараа захирах хэмжээгүй эрхт төрийн эсрэг ажилчин ангийн төрийг байгуулахын төлөө марксист үзэл суртлыг өөрийн мөрдлөг болгосон бүлэг юм. |
| 2. Большевик | b) Тус байгууллага нь Монголын үндэсний ардчилсан хөгжлийн замыг таслан зогсоохын тулд коммунизмыг чиг баримжаа болгосон үзэл санааг тус орны албан ёсны үзэл суртал болгоход чиглэсэн үйл ажиллагааг явуулж, Монголын нөхцөлд хэрэгжих боломжгүй тогтоол шийдвэрийг гаргаж байв. |
| 3. Тоталитар дэглэм | c) Коминтернээс хэрэгжүүлсэн улс орныг нийгэм журмаар хөгжүүлэх чиглэлийг дэмжигчид, бусдыг дууриан өрөөлийн заавраар явагчид |
| 4. Зүүнтэн | d) Төрийн дээд эрх мэдэл нь нэг буюу цөөн бүлэг хүний гарт төвлөрсөн, нийгмийн амьдралын бүх хүрээнд төр өөрийн хатуу хяналтаа тогтоодог дэглэм. |
| 5. Соёлын довтолгоон | e) Монгол орны нийгэм, эдийн засгийг бодлого |

- | | |
|----------------------------|---|
| 6. Социалист систем | f) Тухайн мөчид бодит байдал дээр тусгаар оршин байгаа байдлыг төр засаг, нутаг дэвсгэрийн хэмжээнд хүлээн зөвшөөрөх утга агуулга илэрхийлдэг. |
| 7. Сэхээтний төөрөгдөл | g) Хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн гэх утгатай, нэг улсыг нөгөө улс нь албан ёсоор хүлээн зөвшөөрч оршин тогтнож буйг илэрхийлэх хэлбэр |
| 8. Статус кво | h) Улс орныхоо төлөө сэтгэл зовниж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, нам, төрийн удирдлагын алдаа дутагдлыг шүүмжилсэн сэхээтнүүдэд МАХН-ын удирдлагаас өгсөн нэр |
| 9. De jure | i) Амьжиргааны хэв маяг, ахуй соёлын хуучирсан дадал, хэвшлийг халан өөрчилсэн үйл явц |
| 10. Шинэ эргэлтийн бодлого | j) Дэлхийн II дайны дараа Зүүн Европын Албани, Болгар, Унгар, Зүүн Герман, Польш, Румын, Чехословак, Югослав, Азийн Вьетнам, Хятад, Умард Солонгос зэрэг орнууд социализмын замаар замнах болсноор үүссэн тогтолцоо |

В. Өгөгдсөн үгсийг өгүүлбэрт тохируулж бичнэ үү.



Ялтын бага хурал, Соёлын довтолгоон, Үндсэн хууль, Хялганатын хүрээ, Сэхээтний төөрөгдөл Улсын Их Хурал, Харилцан туслалцах протокол, Барууны аюул, Зүүнтнүүдийн, Монгол Ард

1. 1921 оны хувьсгал ялсны дараа _____ боловсруулах ажил эхэлжээ.
2. БНМАУ-ын төрийн дээд эрхийг _____-д хадгалах ба хурлын чөлөө цагт Улсын Бага Хурал, мөн хурлын чөлөө цагт Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалахаар хуульчилж төрийн эрх мэдлийг хуваарилсан байна.
3. МАХН-ын их хурлын өмнө хуралдсан бүгд хурлын үеэр зарим оролцогчдыг “боловсруулах”, айлган сүрдүүлэх, дарамтлах зэргээр ажиллаж _____ гэгчийг илчлэх ажлыг зохион байгуулсан байна.
4. _____ алдаатай бодлого, үйл ажиллагааны уршгаар БНМАУ-ын эдийн засаг, нийгмийн амьдрал гүн гүнзгий хямралд оров.
5. 1932 оны 4-р сарын 12-нд Хөвсгөл аймгийн Рашаант сумын _____ зэвсэгт бослого дэгджээ.
6. 1936 оны 3-р сарын 12-нд БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд _____ -ыг Улаанбаатар хотноо байгуулж, “хэрэв энэхүү гэрээ тогтоосон нэгэн этгээдийг цэргийн хүчээр довтолбол бие биедээ элдэв тусламж, мөн цэрэг зэвсгийн тусламж үзүүлэх үүрэх хүлээх”-ээр тогтжээ.
7. 1945 оны _____ дээр ЗХУ, Их Британи, АНУ-ын удирдагчид “Гадаад Монголын статус кво”-г хүлээн зөвшөөрөх тохиролцоонд хүрчээ.
8. Монголын ард түмний хөрөнгөөр Хувьсгалт Монгол Улс танкийн цуваа, _____ нисэх онгоцны эскадрилыг байгуулж, 1942, 1943 онд Улаан армид шилжүүлэв.
9. Ард түмний соёлын түвшинг дээшлүүлэх, ялангуяа ахуйд соёл нэвтрүүлэхэд 1959-1961 онд зохион байгуулсан _____ кампанит ажил чухал үүрэг гүйцэтгэжээ.
10. 1956 оны намын бүгд хурлын дараа шүүмжлэлт уур амьсгал идэвхжив. Намын Төв Хороо ямар ял зэмлэл хүлээлгэхгүй, та бүхэн санал бодлоо чөлөөтэй уралдуул гэж яриулчихаад, 1956 оны XII сард Улс төрийн товчоо тогтоол гаргасан байна. Уг тогтоолд улс орны хөгжлийн талаарх шүүмжлэл, санал бодлыг _____ гэж буруутгажээ.

С. Түүхийн зарим үйл явдлуудыг зөв танилцуулсан эсэхийг (зөв +, I II III буруу -) тэмдэглэнэ үү.

Түүхэн үйл явдлууд	Зөв	Бур уу
Анхдугаар Үндсэн хуулиар Монгол Улсыг “Олноо өргөгдсөн” хэмээн нэрийдэв.		
Баруунтан гэгдэх хүмүүс нь аливаад уян хатан, үндэсний онцлогоо харгалзсан бодлого явуулж, шашин, сүм хийд, лам нар, хүн амын орлогын татвар, хөрөнгө хураалтын талаар аядуу бодлого баримталж, эдийн засгийн хувьд нэг улсын хараат байхаас сэрэмжлэн, дэлхийн олон улстай эрх тэгш харилцахыг чухалчилж байв.		
Шинэ эргэлтийн бодлого нь эдийн засгийн хямралыг гэтэлгэх, үйлдвэрлэх хүчнийг нэмэгдүүлэх, малчдын мал маллах сонирхлыг дахин сэргээх, малын тоо толгойг өсгөхөд чиглэжээ.		
“Лхүмбийн хэрэг” гэдэг нь 1939 оны IX сарын 10-ны шөнө 75 хүнийг хувьсгалын эсэргүү, японы тагнуул гэгдсэн 115 хүний нэрсийн жагсаалтыг авч ирснээр эхэлдэг.		
Халх голын дайны үйл ажиллагааг маршал Х. Чойбалсан бүхэлд нь удирдаж байв.		
Монголчууд ард түмний хүч хөрөнгөөр бэлтгэсэн бэлэглэлийг найман удаагийн цуваагаар 700 гаруй вагон ачаа хүргэж байв.		
БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газар өөрийн орны төрийн тусгаар тогтнолын асуудлаар бүх ард түмний санал хураах ажлыг 1945 оны X сарын 20-нд явуулах тогтоол гаргажээ.		
1951 онд Улсын Багшийн Дээд Сургууль, 1950-1960 оны заагаар МУИС-аас Анагаах Ухааны Дээд Сургууль, Хөдөө Аж Ахуйн Дээд Сургууль бие даан гарсан байна.		
1960 оноос манай орон өөрийн хөгжлийн шинэ үе, социалист нийгмийг байгуулж дуусгах үедээ орсон гэж тунхаглаж, энэ үеийн гол зорилт бол социализмын материал техникийн баазыг байгуулах ажлыг бүх талаар гүнзгийрүүлэн дуусгах явдал гэж үзэж байлаа.		
БНМАУ-ын хөдөө аж ахуйн хөгжилд гарсан нэг том өөрчлөлт бол атар газрыг эзэмшин, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн явдал мөн.		
Улсын анхдугаар Үндсэн хуулиар улсын нийслэлийг Нийслэл хүрээ хэмээн нэрлэж, Их хүрээ нэрийг халжээ.		

2. Дасгал, даалгавар

А. Анхдугаар Үндсэн хуулийн талаарх талуудын байр суурийг бичнэ үү. I II III

Анхдугаар Үндсэн хууль	
Монголын талын байр суурь	Зөвлөлтийн талын байр суурь

В. Үгийн сүлжээг бөглөнө үү. I II III


БОСОО

- 1) 1922 онд Үндсэн хууль боловсруулах комиссыг байгуулахад хэнээр ажлын хэсгийг ахлуулж байсан бэ?
- 2) Үндсэн хуулиар төрийн дээд эрх мэдлийг барина гэж заасан байдаг.
- 3) 1932 оноос эхлэн зүүнтний учруулсан хор уршгийг арилгах журмаар хэрэгжүүлж эхэлсэн төрийн бодлогын нэршил

- 4) Зүүнтний хэрэгжүүлж эхэлсэн нэгдэлжүүлэх бодлого мал сүргийн тоо толгойд хэрхэн нөлөөлсөн бэ?
- 5) Үндсэн хуулийн зорилго заалтад нийгмийн ямар бүлгийн эрх ашгийг ноцтой хөндөж, жинхэнэ бус ард гэж үзэж байсан бэ?
- 6) Нам төрийн ангичлах ард түмнийг үзэл суртал, шашнаар шахан хавчих хатуу бодлого явуулснаас үүдэн 1932 онд ямар үйл явдал гарсан бэ?
- 7) Дотоод явдлын яамны ерөнхий сайдаар 1936 онд хэн томилогдсон бэ?
- 8) Хэлмэгдэлтэнд хамгийн ихээр өртсөн хүмүүс
- 9) Хамтрал нь дотроо коммун, артель..... гэсэн хэлбэртэй байна.
- 10) Коминтерноос-ны үзэл хандлагатай хүмүүсийг үзэхдээ ЗХУ-ыг эсэргүүцдэг,нармай монгол үзэлтэй, шашныг ариунаар мандуулах эрмэлзэлтэй гэж буруутгаж шахаж хавчиж байв.

ХӨНДЛӨН

- 1) Монгол улсын үндсэн хуульд анх удаа.....-ийг тусгаж ард түмнийг төрийн үйл хэрэгт оролцох эрх чөлөөг тунхагласан.
- 2) Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн даргаар хэнийг нэр зааж сонгосон бэ?
- 3) ЗХУ бодлогыг Коминтерний заавраар шууд Монголын хөрсөн дээр буулгаж хэрэгжүүлж байсан хүмүүсийг түүхэнд хэрхэн нэрлэсэн бэ?
- 4) 1924 оны Улсын анхдугаар их хурлаар хэлэлцэн гаргасан хууль тогтоомжийг юу гэж нэрлэн баталсан бэ?
- 5) Улсын анхдугаар хурлаас гарсан Үндсэн хуулийн заалт ёсоор улсын нийслэлийг ямар нэрээр өөрчилсөн бэ?
- 6) Зэвсэгт бослого анх аль аймагт гарсан бэ?
- 7) 1934-1940 оны хэлмэгдүүлэлтийн оргил үеийг түүхэнд юу гэж тэмдэглэсэн байдаг вэ?
- 8) Феодалын хөрөнгө хураах Төв комиссыг хэдэн хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бэ?
- 9) Угсаа сурвалжгүй, хөрөнгө чинээгүй эгэл хүнийг 1924-1944 онд Үндсэн хуульд юу гэж заасан байдаг вэ?
- 10) Зүүнтний явуулсан бодлого шийдвэрээс ард түмний амьдралыг дордуулж, дургүйцэл эсэргүүцлийг ихээр төрүүлж байсан алдаатай бодлогуудын нэг нь юм.



С. Сурвалжийн мэдээ, өөрийн мэдлэгт тулгуурлан асуултад хариулна уу.



Аливаа хурлын төлөөлөгчдийг сонгох ба сонгогдох эрхгүй хүмүүс нь

- Ямагт ашгийг эрмэлзэж бусдыг зарж мөлжин амьдрагчид
- Ямагт бусдыг хөлслөн зарах ба хөрөнгө орлого зэргийн үзлээр амьдрагч жинхэнэ худалдааны ба мөнгө хүүлэгчид
- Урьдын ван, гүн ба хутагт хувилгаад, жич орон хийдэд үргэлж суух санваартан лам нар
- Солиорсон ба ухаан эвдэрсэн бөгөөд зохих газраас шинжлэн батлагдагсад
- Эд хичээх зэргээр нэрийг гутаах явдал үйлдэж, зарга шүүх газраас ял шийтгэгдэгсэд болно

(Анхдугаар Үндсэн хууль 35-р зүйл)

- Тус ул харьяат аливаа хүний шүтэх итгэх явдалд бүрнээ эрх чөлөө тулд шашны хэргийг улс төрийн хэргээс тусгаар байгуулж, шашин шүтлэгийн явдлыг өөр өөрийн дур сүсгээр болговол зохино.
- Элдэв хэргийг жинхэнэ ард түмнээр шүүмжлэх эрхийг хүндэтгэж, тус улсаас аливаа хэвлэх, нийтлэх явдлыг бүртгэн гүйцэлдүүлбэл зохино.
- Тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино.
- Жинхэнэ олон ардын аливаа эрдэм соёлд гэгээрүүлэх замыг нээгдүүлэн тус улсаас элдэв ухааны эрдэмд бүрнээ үнэ төлбөргүйгээр боловсруулах явдлыг гүйцэтгэвэл зохино.

(Анхдугаар Үндсэн хууль 3-р бүлэг)


БНМАУ-ын анхдугаар Үндсэн хууль хэдийд, хэрхэн батлагдсан бэ?

Анхдугаар Үндсэн хуулинд хүний эрхийг хэрхэн тусгасан бэ?

Анхдугаар Үндсэн хуулийн давуу болон сул талууд юу юу байсан бэ?

3. Дасгал, даалгавар

А. Улс орны хөгжлийн талаарх талуудын байр суурь, үзэл баримтлалын ялгааг нийгмийн амьдралын хүрээ тус бүрээр хүснэгтэд бичнэ үү.



Улс орноо хөгжүүлэх чиг хандлага	
Үндэсний ардчилсан үзэтнүүд	Зүүнтнүүд
Нийгэм эдийн засаг	
Улс төр	
Гадаад харилцаа	


В. Шинэ эргэлтийн бодлогын шалтгаан, үр дагаврыг (тус бүр 2-3) тодорхойлно уу.

Шинэ эргэлтийн бодлого
Шалтгаан
Үр дагавар

С. Шинэ эргэлтийн бодлогын ач холбогдлыг дүгнэж бичнэ үү?

4. Дасгал, даалгавар

А. Хэлмэгдүүлэлттэй холбоотой мэддэг үйл явдлаа он цагийн дарааллаар бичнэ үү.



В. Сурвалжийн мэдээ, өөрийн мэдлэгт тулгуурлан асуултад хариулна уу.



Сурвалж 1

“Лхүмбийн хэрэг” гэж нэрлэгдсэн, олон хүнийг хамарсан энэ завхрал... эхнээсээ аваад эцсээ хүртэл огт худал, зохиомол гүтгэлэг байжээ. Эдгээр “хэрэг”-т гэмт хэргийн бүрдэл, хэргийг нотлох эд мөрийн баримт огт байсангүй


(МАХН-ын Төв Хорооны бүгд хурлын илтгэлээс, 1962)

Сурвалж 2

Хүнийг сэжиг таавраар дайчлан баривчлах, мөрөн байцаалтыг хууль бус аргаар явуулж, тулган хавчих замаар хилс хэрэг хүлээлгэж, нэрсийн жагсаалтаар Онц бүрэн эрхт комисс оруулан үй олноор нь буудан алах явдал Дотоод яамны энэ үеийн үйл ажиллагааны гол арга болж байжээ.Хэзээ хэнд элссэн, хэнийг элсүүлсэн бэ гэдэг асуулт голлон тавьж олон хүний нэр гаргуулах болсон нь хэргийн материалуудаас тодорхой харагдаж байна. ... Хүний бие махбодийг тарчилган зовоох эрүү шүүлтгийн өөр нэг хэлбэр бол хорих журам байжээ. Нэг дор үй олон хүн оруулж, унтах, хэвтэх, сууж амрах босоо байлгаад, шөнөд нь аваачин удаан цагаар мөрдөж, хүнийг тэсвэрлэшгүй байдалд оруулж нойроор хавчин зовоодог байсан. ... мөн цементэн шалтай дэвсгэргүй, гал түлдэггүй хүйтэн жижиг өрөөнд хүнийг дан ганц өмд цамцтай нь оруулж түгжээд цонхыг нь онгорхой байлгаж осгоодог харгислал 1949 он хүртэл хэрэглэгдэж байжээ.

(“Улсын аюулаас хамгаалах байгууллагын ажилд гарч байсан алдаа завхралыг шалгасан дүнгийн тухай” илтгэлээс 1962)

Сурвалж 3. БНМАУ-ын Ерөнхий сайд Агданбуугийн Амар улс төрийн хилс хэрэгт гүтгэгдэн Москвад хоригдож, цаазын ял сонсохын өмнөх үеийн зураг. 1941 он



“Тулгаж буй ялыг ойлголоо. Урьдчилсан байцаалт дээр надад хүчээр тулган хүлээлгэсэн учир түүн дээр өгсөн мэдүүлгээсээ татгалзаж байна. БНМАУ хэрэв тусгаар тогтносон улс юм бол яагаад Зөвлөлтийн шүүх намайг шүүж байгаа юм бэ? Би БНМАУ-ын иргэн, тиймээс Зөвлөлтийн шүүх биш Монголын шүүх намайг шүүх ёстой... Би ЗХУ-ыг үздэггүй, коммунист намд хэтээсээ дургүй. Би Монголын ард түмэндээ хайртай, би Оросын ард түмэнд элэгтэй, харин улаантан, тэдний засагт дургүй. Учир нь тэд аливаа том гүрний адил Монгол Улсыг эзлэн түрэмгийлэх бодлого явуулж байна. Манай Монгол Улсын хил залгадаг учир ЗХУ-тай ч, Японтой ч дотносохыг би хүсдэггүй. Монгол улсаас хол учир Герман улстай холбоо тогтоохоор хичээж байна. БНМАУ-ын хувьсгалын эсэргүү, нармай Монголын тагнуул хуйвалдааны байгууллагын удирдагчдын нэг гэж намайг буруутгаж байна. БНМАУ-д хувьсгалын эсэргүү ямар ч байгууллага байгаагүй. Би Зөвлөлтийг эсэргүүцдэг, түүнийгээ нууж хааж байгаагүй, нуух ч үгүй, Хүчинд автаж аргагүй байдалд хүрч өгсөн миний мэдүүлэг гэгчээр баригдсан улсууд бол хувьсгалын эсэргүүнүүд огт биш. Тэднийг гэм зэмгүй байхад нь баривчилсан. Урьдчилсан байцаалт дээр манай олон монголчууд хатуу ширүүнээр тамлуулсны учир өөрсдийнхөө тухай болон бусдын талаар худал мэдүүлэг өгсөн. Гэхдээ тэд цөм буруугүй хүмүүс. Хэтээсээ том улс үндэстэн бага буурай улс үндэстнийг түрэмгийлэн эзэлж, удирдагчдыг нь барьж хорьдог. Яг л ийм маягаар ЗХУ Монгол Улсад хандаж байгаа. Түүний тод жишээ нь миний буюу”

Асуулт 1. Гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоохдоо хүнлэг бус арга хэрэглэх нь зохистой юу? Хэлмэгдүүлэлтийн үед ямар хүнлэг бус аргуудыг хэрэглэдэг байсан бэ?

Асуулт 2. “Зохиомол хэрэг” гэж юу гэсэн үг бэ? Яагаад “зохиомол хэрэг” тулгаж ял хүлээлгэдэг байв?


Асуулт 3. Хэлмэгдүүлэлттэй холбогдох хамгийн сайн мэддэг үйл явдлынхаа талаар бичнэ үү.

Асуулт 3. Хэлмэгдэгсдийг цагаатгах талаар төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг та хэрхэн үнэлж байна вэ?

C. Сурвалжийн мэдээ болон өөрийн мэдлэгт тулгуурлан доорх хүснэгтэд тэмдэглэл хөтөлнө үү.

Шалтгаан	<hr/> <hr/> <hr/> <hr/>
Түүхэн хүн	<hr/> <hr/> <hr/> <hr/>
Хор уршиг	<hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>
Түүхэн сургамж	<hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>

D. Хэлмэгдүүлэлтийг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн залгамж холбоонд нь тайлбарлана уу.



5. Дасгал, даалгавар

А. Халх голын дайнтай холбогдох үйл явдлуудыг он цагийн дарааллаар (1-6) дугаарлаж тэмдэглэнэ үү.

I	II	III
---	----	-----

	БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд Харилцан туслалцах протоколыг Улаанбаатар хотноо байгуулж, “ Хэрэв энэхүү гэрээ тогтоосон нэгэн этгээдийг цэргийн хүчээр довтолбол бие биедээ элдэв тусламж, мөн цэрэг зэвсгийн тусламж үзүүлэх үүрэг хүлээх”-ээр тогтжээ.
	Япон, Манжгогийн тал Монгол руу довтлон хилийн зарим нутгийг эзлэн авчээ.
	Японы эрх баригчид Азид түрэмгийллээ идэвхжүүлж, Зүүн хойт Хятад, Өвөр Монгол, Манжуурыг эзэлж Манжго хэмээх улс байгуулжээ.
	Манжуур өртөөнд БНМАУ ба Манжгогийн төлөөлөгчдийн хэлэлцээр эхэлсэн боловч энэхүү хэлэлцээр үр дүнд хүрсэнгүй.
	ЗХУ, Япон хоёр байлдааны ажиллагааг бүрэн зогсоох тухай гэрээ байгуулснаар Халх голын дайн дуусчээ.
	БНМАУ-ын Засгийн газрын хүсэлтийн дагуу Зөвлөлтийн анги нэтгэлүүд манай орны нутагт ирж, тус улсын дорнод хязгаарт байршив.

В. Халх голын дайн, Чөлөөлөх дайнтай холбогдох үйл явдлуудыг ялган хүснэгтэд бичнэ үү.

- 1) БНМАУ империалист Японыг бут цохих шударга үйлсэд хувь нэмэр оруулах, өөрийн орны аюулгүй байдлыг бэхжүүлэх ариун зорилгын үүднээс 1945 оны VIII сарын 10-нд Японд дайн зарлав.
- 2) Япон Манжгогийн талаас БНМАУ-ын хилийг зөрчих, хилийн харуул руу довтлох, хил орчмын хүн ардыг түйвээн дээрэмдэх явдал өргөжиж, Халхын сүмийг цэргийн хүчээр эзлэн авчээ.
- 3) Японы талын цэрэг улс төрийн бодлого нь ЗХУ-ын дорнод хэсгийг эзлэн авахын тулд Монголын газар нутгийг эзлэн авч, улмаар өөрийн түшиц газар болгох явдал байв.
- 4) Монгол-Зөвлөлтийн цэрэг Өвөр Монгол ба Хятадын нэлээд нутгийг чөлөөлөн, Квантуны армийг Хятадын бусад нутгуудад байлдаж байсан зэвсэгт хүчнээс нь тасалсан юм.
- 5) Уг дайнд Лувсанцэрэнгийн Аюуш, Дашийн Данзанваанчиг, Сангийн Дампил, Пунцагийн Чогдон, Дүгэрийн Нянтайсүрэн, Магсарын Жанчив нарын зэрэг БНМАУ-ын баатрууд төрөн гарав.
- 6) Баянцагааны тулалдаан нь Японы талаас Халхын голыг гатлан давших гэсэн эхний бөгөөд эцсийн оролдлого байсан ба дахин голын эрэгт гарч чадаагүй билээ.
- 7) БНМАУ-ын Засгийн газар цэргийн мөргөлдөөнийг өргөтгөхгүй байх, хилийн будлианыг яриа хэлэлцээрийн замаар зохицуулах санал тавьж байв.
- 8) БНМАУ Дэлхийн II дайны төгсгөлд шууд оролцож, дорно дахинд энх амгалан тогтооход өөрийн хувь нэмрээ оруулсан билээ.

Халх голын дайн	Чөлөөлөх дайн

С. Халх голын дайн, Чөлөөлөх дайны холбогдох үзүүлэлтийн дагуу харьцуулж тэмдэглэнэ үү.

I II III

Харьцуулах үзүүлэлт	Халх голын дайн	Чөлөөлөх дайн
Цаг хугацаа		
Түүхэн хүмүүс		
Газар нутаг		
Шалтгаан		
Үр дагавар		

D. Түүхэн зураг, өмнөх мэдлэгтээ тулгуурлан асуултад хариулна уу.
Зураг 1. Зураг 2.

I II III



Асуулт 1. Түүхэн зураг 1, 2 ямар мэдээлэл өгч байна вэ?

Асуулт 2. Дайны үеийн нөхцөл байдал нь Монголын нийгэм-эдийн засгийн амьдралд ямар нөлөө үзүүлсэн бэ?

Асуулт 3. БНМАУ Зөвлөлтийн ард түмэнд тусалсан шалтгаан, ач холбогдлыг хэрхэн тодорхойлох вэ?


6. Бие даан ажиллах дасгал, даалгавар



А. 1940-1990 онд холбогдох зарим гол үйл явдлуудыг он дарааллын шулуунд дарааллаар байрлуулна уу? Амжилттай болсон үйл явдлыг дээш чиглэсэн суманд, алдаа оноотой гэж үзсэн үйл явдлыг доош чиглэсэн суманд тэмдэглэнэ үү.

- 1) Шинжлэх ухааны хүрээлэнг Шинжлэх Ухааны Академи болгон өөрчлөн байгуулав.
- 2) Ялтын бага хурал дээр ЗХУ, Их Британи, АНУ-ын удирдагчид “Гадаад Монголын статус кво”-г хүлээн зөвшөөрөх тохиролцоонд хүрчээ.
- 3) Нэгдэлжих хөдөлгөөн ялсны 20 жилийн ойн үеэр БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Ю. Цэдэнбал хөдөөгийн жижиг үйлдвэрлэгчдийг хоршоолох замар социализмд дэвшүүлэн оруулах үйл хэргийг амжилттай шийдвэрлэсэн нь БНМАУ ба Монголын ард түмний амьдралд ач холбогдлоороо 1921 оны ардын хувьсгалтай тэнцэхүйц үлэмжхэн түүхэн үйл явдал болсон гэж дүгнэв.
- 4) Сэхээтний доторх шүүмжлэлт уур амьсгалыг “сэхээтний төөрөгдөл” гэж нэрлэв.
- 5) Монголын эрдэмтэд сансар судлалын “Интеркосмос” программыг хэрэгжүүлэх ажилд гар бие оролцож, Монгол хүн сансарт нисэв.
- 6) МАХН –аас хувийн өмчийг үгүйсгэн нийгмийн өмчийг тулгаж, нэг үзэл суртлыг тунхаглах болсноор улс төр, эдийн засаг, үзэл суртлын хүрээнд төвлөрөл хүчтэй болов.
- 7) БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай бүх нийтийн санал хураалт явагдав.

- 8) Бүх нийтийг бичиг үсэгтэй болгох хөдөлгөөн үр дүнгээ өгч, хүн амны 89.3 % нь бичиг үсэг тайлагдсаныг ЮНЕСКО үнэлж Н. Крупскаягийн нэрэмжит олон улсын алтан медалиар манай улсыг шагнасан юм.
- 9) “Мандухай сэцэн хатан” кино дэлгэцнээ гарсан нь манай кино урлагийн томоохон үйл явдал байлаа.



В. 1940-1990 оны хооронд болсон зарим гол үйл явдлуудыг шалтгаан, үр дагаврыг тодорхойлно уу.

Зарим гол үйл явдлууд	Шалтгаан	Үр дагавар
Монголын бүх ард түмний санал хураалт		
Анхдугаар таван жилийн төлөвлөгөө		
Атар анхдугаар аян		
Соёлын довтолгоон		
Нэг хүнийг тахин шүтэх явдал		
БНМАУ НҮБ-д элссэн		

7. Бие даан ажиллах дасгал, даалгавар

А. Сурвалжид үндэсэн асуултад хариулна уу.

- 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулинд хөгжлийн зорилтыг хэрхэн тодорхойлсон байна вэ?
- Үндсэн хуулийн ач холбогдлыг тайлбарлана уу.

Сурвалж 1. Анхдугаар Үндсэн хууль	Сурвалж 2. БНМАУ-ын Үндсэн хуулиас 1940	Сурвалж 3. БНМАУ-ын Үндсэн хууль 1960
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зорилт бол хуучны эзэрхэг харгисын ёс суртлын үлдэгдлийг үндсээр устгаж, улс төрийн захиргааны явдлыг жинхэнэ ардын ёсонд нийцүүлж шинэ ёсны Бүгд Найрамдах Улсын үндэс тулгуурыг бататган бэхжүүлнэ.	“БНМАУ бол эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан, цаашид нийгэм журамд давшин орохын учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий хөдөлмөрчин ардын тусгаар тогтоосон улс мөн болно”	БНМАУ бол ажилчид, хоршоолсон ардууд (малчид, тариаланчид), хөдөлмөрч сэхээтний социалист улс бөгөөд түүний үндэс нь ажилчин анги, хоршоолсон ардын холбоо мөн.
<hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>	<hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>	<hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>

В. Шүлэг, ерөөлийг уншин, Танд түүхэнд болсон ямар үйл явдлын талаар, ямар мэдээлэл өгч байгааг тэмдэглэнэ үү? Яагаад гэдгээ тайлбарлаарай. Тухайн үйл явдлын эерэг болон сөрөг талуудыг тодорхойлно уу.

<p>Сурвалж 1. Төрийн шагналт, яруу найрагч Ч. Лхамсүрэн</p> <p>Хөх тэнгэрт нисэх онгоцоор Хөвсгөл нуур хөлөг онгоцоор Хөдөө талд галт тэргээр Хөндлөн гулд хурдан мориор Гэгээн гэрэлт соёл багш Гэр байшин хэсэж явна. Ширүүн зантай гахай туугаад Сэрээ барьсан матар хөтлөөд Соно, хэдгэнэ хоёроо дагуулаад Бадрангуй хүчит соёл багш Баатар жанжин шиг довтолж явна</p>	<p>Сурвалж 2. Ардын уран зохиолч Ц. Дамдинсүрэнгийн Маршал Чойбалсанд зориулсан ерөөлдөө</p> <p>Таны насалсан Тавин жил бол Тайван цагийн Мянган жилтэй тэнцэнэ Хоёр гурван мянган жилийн Хосгүй түүхт их хэргийг Хорлоогийн хүү Чойбалсан бүтээлээ.</p>
---	--

<p>Сурвалж 1 Ямар мэдээлэл өгч байна вэ?</p> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>		<p>Сурвалж 2 Ямар мэдээлэл өгч байна вэ?</p> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>	
Эерэг тал	Сөрөг тал	Эерэг тал	Сөрөг тал

С. Сурвалжид үндэслэн асуултад хариулна уу.

БНМАУ-д социализм байгуулж дуусгах үед МАХН-аас тавих гол зорилт бол орчин үеийн шинжлэх ухаан техникийн дэвшилтийн ололтыг үндэс болгож, социалист нийгмийн үйлдвэрлэх хүчнийг бүхий л талаар хөгжүүлэх, тус орны эдийн засгийн хүч чадал, социалист соёлыг түгээн хурдацтай өрнүүлэх, нийгмийн социалист харилцааг боловсронгуй болгох, хөдөлмөрчдийг коммунист ёсоор хүмүүжүүлэх ажлыг хүчтэй болгох улмаар ард түмний аж амьдралын байдал, соёлын хэмжээг цаашид дэлгэрүүлэх явдал мөн. Энэ үеийн эдийн засгийн гол асуудал бол улс орноо цаашид үйлдвэржүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг механикжуулах, улс ардын аж ахуйн бүх салбарын техник хангамжийг дээшлүүлэх зэргээр социализмын материал техникийн бааз байгуулж дуусгах явдал мөн.
(МАХН-ын IV программаас 1966)

Асуулт 1. Социализмын материал техникийн бааз байгуулах гэдгийг хэрхэн ойлгож байна вэ?

Асуулт 2. Социализмын материал техникийн бааз байгуулах зорилт биелсэн үү? Тодорхой баримтад тулгуурлан тайлбарлана уу?

I	II	III
---	----	-----

8. Бие дааж ажиллах дасгал, даалгавар

А. Ю. Цэдэнбал “Хувийн аж ахуйг хоршоолсон нь 1921 оны хувьсгалтай танцэхүйц ач холбогдотой болсон” гэдэг дүгнэлттэй санал нийлэх үү? Яагаад?

В. Атар газар эзэмшсэнийг эерэг, сөрөг талуудыг хэрхэн дүгнэх вэ?

С. Аж үйлдвэр, дэд бүтцийн салбарт гарсан амжилт ололтыг тодорхой баримтад үндэслэн танилцуулна уу.

Д. Социализмын үед уран зохиолын бүхий л төрөл зүйлс хөгжсөн болохыг нотолно уу.

9. Дасгал, даалгавар



А. Сурвалжуудыг уншиж, мөн өөрийн мэдлэгт тулгуурлаж дараах даалгавруудыг гүйцэтгэнэ үү.

Сурвалж 1.

“... Хүн бүр бага балчраасаа эхлэн туйлын аж ахуйч, арвич хямгач, социалист нийгмийн эс ширхэг бүрийг алхам тутамдаа нүдлэн хамгаалагч, хөдөлмөрийг бишрэн шүтэгч байх ёстой”.

“... Хир буртаг өчүүхэн ч хүргэхгүй нандигнан хайрлаж, тахин шүтэж байх зүйл маань нэгдүгээрт нийгмийн өмч, хоёрдугаарт социалист өмчийг цогцлоон бүрдүүлэгч эх үүсвэр болсон ариун цагаан хөдөлмөр мөн”.

МАХН-ын Төв Хорооны тогтоолоос (1979)

Сурвалж 2.

“... Феодалын байлдан дагуулалт, хаад ноёдын хоорондын тэмцлийг хэт тоочин түүхийг бүтээгч ард түмний роль, ангийн тэмцлийг үгүйсгэсэн байна... “БНМАУ-ын дээж бичиг”-т хятадын сурваж бичгээс 120 гаруй ишлэл авсан атлаа марксизм –ленинизмын үндэслэгчдийн зохиол бүтээлээс нэг ч ишлэл авч тусгаагүйн дээр ардын хувьсгалын түүхийн баримт бичиг, БНМАУ-ын түүхийн гурван боть зохиол зэрэг чухал сурвалж материалаас 20 гаруйхан ишлэл оруулсан нь эмхтгэгчид (Г.Сүхбаатар, Л. Жамсран) Хятадын дарлагч ангийн эрх ашгийг хамгаалсан хуучин сурвалж бичгийг түүхэн үнэ цэнэтэй мэтээр товойлгосныг харуулж байна.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны тогтоолоос (1980)

Сурвалж 1, 2-ийн утга санааг тайлбарлана уу.

Сурвалж 1	Сурвалж 2

--	--

Асуулт 1. Сурвалж 1-д тулгуурлан социализмын үеийн хүмүүсийн амьдралын хэв маягийг хэрхэн дүгнэх вэ?

Асуулт 2. Сурвалж 2-т эрдэмтдийн ямар эрхэнд халдсан бэ? Яагаад

В. Социализмын үеийн хүмүүсийн ахуй, амьдралд гарсан өөрчлөлтийг харьцуулан дүгнэж бичнэ үү?

Эерэг тал	Сөрөг тал
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>
<hr/>	<hr/>

БҮЛЭГ СЭДЭВ: ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛ УЛС

АГУУЛГЫН ХУРААНГУЙ

1990 оноос Монгол Улсын түүхэн хөгжлийн шинэ үе шат эхэлсэн юм. Энэ бол өнөөгийн төдийгүй цаашдаа олон жил монголын түүхийг тодорхойлон үргэлжлэх ардчилал, шинэчлэлийн эрин үеийн эхлэл байсан бөгөөд бидний өмнө туулж өнгөрүүлсэн түүхэн цаг үеийн үр хөврөл, шууд үргэлжлэл болно. 1980-аад оны дунд үе гэхэд социалист систем бүхэлдээ нийгмийн гүн гүнзгий хямралд автагдсан нь тодорхой болж, энэ нь эцэстээ социалист тогтолцоо богино хугацаанд задран унахад хүргэсэн юм. Өөрөөр хэлбэл, социалист систем задран унасан нь улс төр, эдийн засаг, нийгэм, оюун санааны хүрээнд бүрэлдэн бий болсон бодит түүхэн нөхцөл, шалтгааны үр дүн байлаа. Социалист системийн бүрэлдэхүүнд албан ёсоор багтаж байсан БНМАУ-ын хувьд дэлхий нийтийн хөгжлийн нийтлэг хандлага, жишигт нийцүүлэн улс орондоо ардчилсан нийгмийг цогцлоон байгуулах цоо шинэ зорилт дэвшигдэн тавигдлаа. Социалист системийг бүхэлд нь залуурдаж, хяналтандаа тогтоон барьж байсан ЗХУ, түүний удирдагч М.С. Горбачёв 1985 онд өөрчлөн байгуулалтыг (перестройка) тунхагласан нь БНМАУ болон бусад социалист системийн орнуудад өөрчлөлт, шинэчлэлийн хөдөлгөөн өрнөх боломжийг нээж өгсөн билээ.

Хуучин нийгмийн тогтолцоог халж, ардчилсан нийгэмд шилжих энэхүү үйл хэргийн оргил нь 1990 оны ардчилсан хувьсгал байлаа. 1990 оны хувьсгалаар Монголчууд социализмаас ардчилал, чөлөөт зах зээлийн нийгэмд хүчирхийллийн бус, тайван замаар шилжиж болдгийг дэлхий дахин харуулж чадав. Хувьсгалын үр дүнд монголын нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан хувьсгалт өөрчлөлт, шилжилтийн үйл явц өрнөж, өнөөгийн нийгмийн тогтолцоо бүрэлдэн тогтлоо. 1992 онд шинэ Үндсэн хууль батлан гаргаж, иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаажуулан, иргэн өмчийнхөө эзэн болж, улс орноо өмчийн олон хэлбэр бүхий зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжүүлэв. Нийгмийн оюун санааны амьдралд үзэл бодол, шашин шүтлэг, сэтгэлгээний эрх чөлөө бодитой хэрэгжих болсон гээд чанарын эрс өөрчлөлт, шинэчлэлт энэ үед өрнөв.

Ашигласан материал: *Дэлгэржаргал, П, Чинзориг, Б, Болдбаатар, Б. (ред) МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ. Улаанбаатар 2017, МУИС ПРЕСС*

1. Бие даан ажиллах дасгал, даалгавар



А. Түүхэн зургуудад ямар үйл явдлыг илэрхийлсэн бэ? Энэ үйл явдлын шалтгааны талаар юу мэдэх вэ?



Үйл явдал:

Шалтгаан:

В. 1990 оны ардчилсан хувьсгалтай холбогдох үйл явдлуудыг тэмдэглэнэ үү?

№	Үйл явдлууд	Тийм	Үгүй
1	1956 онд Унгарт, 1968 онд Чехословакт, 1970-аад онд Польшид коммунист дэглэмийг эсэргүүцсэн тэмцэл хөдөлгөөн гарч байв.		
2	Нэг намын дарангуйлал, захиран тушаах дэглэм ноёрхож, ардчилал, хүний эрх, эрх чөлөө тунхаглал төдий оршиж байлаа.		
3	Зөвхөн хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, зах зээлийн эдийн тогтолцоо ноёлж, эдийн засгийн харилцаа эрэлт нийлүүлэлтийн хуулиар зохицуулагдаж байв.		
4	Энэ үед залуучуудын дунд Шинэ үе, Орчлон, Ертөнц зэрэг улс төрийн намууд ээлж дараалан байгуулагдаж, үйл ажиллагаа явуулах болов.		
5	Сосорбарамын Цогтсайхан, Намсрайжавын Энхбаяр Хонхны дуугаа дуулсан нь цаашид ардчилсан хувьсгалын сүлд дуу болон түгэн цуурайтав.		
6	АИХ анх удаа Ерөнхийлөгч сонгох асуудал хэлэлцэн П. Очирбат, Ц. Лоохууз нар нэр дэвшиж, Ц. Лоохууз нь БНМАУ-ын анхны ерөнхийлөгчөөр сонгогдов.		
7	1992.01.13-нд шинэ Үндсэн хуулийг батлан гаргасан бөгөөд энэ нь Монгол Улсад өнөөгийн эрх зүйт тогтолцоо бүрэлдэн төлөвших үндэс болсон юм.		
8	Монголын түүхэнд анхны олон намын оролцоотой, чөлөөт, ардчилсан сонгууль 1990 оны 7-р сарын 22-29-нд явагдав.		
9	Зах зээлийн эдийн засагт шилжих алхмуудыг Р. Гончигдоржийн тэргүүлсэн Засгийн газар анхлан хэрэгжүүлсэн юм.		
10	Монгол Улсад зөвхөн хувийн өмчийн хэлбэр бодитойгоор оршин тогтнох болов.		

C. Социалист байгуулалт яагаад мухардалд ороход хүрсэн бэ? Тодорхой баримтад үндэслэн тайлбарлана уу?

I	II	III
---	----	-----

D. Ардчилсан хувьсгал өрнөх үеийн Монгол Улсын нөхцөл байдлыг хэрхэн төсөөлж байна вэ?

I	II	III
---	----	-----

Гадаад нөхцөл байдал	Дотоод нөхцөл байдал

E. Календарт 1989 онд холбогдох улс төрийн жагсаал хаана болсон, шалтгаан нь юу байсан талаар тэмдэглэл бичнэ үү.
1989 оны 12- р сар

I	II	III
---	----	-----

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30
31						



F. Ардчилсан хувьсгалд холбогдох үйл явдлуудыг хугацаагаар нь эрэмбэлж, тухайн үйл явдлын талаар бичнэ үү?

I II III

G. Хамгийн гол гэж үзсэн үйл явдлынхаа шалтгаан, үр дагаврыг тайлбарлана уу.

Үйл явдлын нэр: _____	
Шалтгаан	Үр дүн
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____
_____	_____

2. Дасгал, даалгавар



А. Сурвалжийг уншиж, асуултад хариулна уу.

Сурвалж 1.

“Залуучуудын сонорт” хэмээх ухуулах хуудас
Энэхүү ухуулах бичгийг
залуучуудын “Шинэ үе” нууц бүлгэмээс 1989 оны
1 сарын 2-ноос 3-нд шилжих шөнө Улаанбаатар
хотын төв гудамж, автобусны буудал, албан
байгууллагуудын үүдэнд сэм нааж байв.

Өөрчлөн байгуулалтын хувь заяа ардчилал, ил
тод байдал, ард олны оюун санааны эрх чөлөө-
чөлөөт сэтгэлгээнээс онцгой хамаарах билээ.

Ийм учраас юуны өмнө:

- 1) БНМАУ-ын АИХ-ын даргыг бүх ард түмний шууд, нууц санал хураалтаар сонгодог журамд шилжих
- 2) Үзэл бодлын плюрализм (олон чиглэл)-ийг албан ёсоор тунхаглаж, ардчилал, ил тод байдлыг баталгаатай болгосон хуулийг ойрын хугацаанд боловсруулан бүх ард түмнээр хэлэлцүүлэн батлуулах
- 3) НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1948.12.12-нд баталж гаргасан “Хүний эрхийн бүх нийтийн тунхаглал”-ыг ард олонд таниулан сурталчилж, амьдралд бүрэн дүүрэн хэрэгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхийг залуус бид нам засгийн удирдлагаас шаардаж байна.

Сурвалж 2.

1990 оны 2 сарын 18-нд МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурал, БНМАУ-ын АИХ-ын чуулганд 13 зүйл бүхий Өргөн барих бичиг гаргав.

Өргөн барих бичгийн зарим заалтууд

- 1) Улс төрийн амьдралыг олон намын системийн үндсэн дээр зохицуулах зарчмыг хууль эрхийн баталгаатай болгож, АИХ-аас намын тухай хууль боловсруулан гаргах
- 2) Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тодорхойлсон хүн, ард, иргэдийн дархан эрхийг төр засаг, намын үйл ажиллагаанд дээдлэн хүндлэх
- 3) БНМАУ-ын АИХ-ыг байнгын ажиллагаатай парламентийн хэлбэрт оруулах
- 4) БНМАУ-ын сонгуулийн системийг шинэчлэх, Ардын Их Хурлын депутатуудыг сонгох бүх нийтийн сонгуулийг 1990 оны эхний хагас жилд багтаан явуулах
- 5) Хэвлэлийн эрх чөлөөг хуулийн баталгаатай болгох,
- 6) Тусгай хангамжийг устгах

Асуулт 2. Ямар учраас энэхүү ухуулах бичгийг нууцаар тараав?

Асуулт 2. Өргөн барих бичгийг яагаад гаргах болов.

В. Дээрх 2 сурвалжид тусгагдсан агуулгын ижил болон ялгаатай талыг бичнэ үү.

“Залуучуудын сонор”-т хэмээх ухуулах хуудас	Өргөн барих бичиг
<p>Ижил талууд:</p> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>	
<p>Ялгаатай талууд:</p> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>	

С. “Залуучуудын сонор”-т хэмээх ухуулах хуудас, Өргөн барих бичгийн зорилго биелсэн гэдэгтэй та санал нийлэх үү? Тодорхой үндэслэлтэй тайлбарлана уу.

3. Дасгал даалгавар



А. Дараах түлхүүр үгсийг өгүүлбэрт нөхөж бичнэ үү.

“Шинэ үе, Орчлон, Ертөнц”, Улс төрийн жагсаал, Өлсгөлөн, Чөлөөт ардчилсан сонгууль, Үндсэн хууль, Марксизм-ленинизм, Перестройка, Монголын ардчилсан нам (МоАН), Монголын ард түмний сонорт хүргэх улс төрийн тунхаглал, Нэг намын ноёрхол

- 1) 1990 оны 3 сарын 07-нд МоАХ-ны арван гишүүн (Э. Бат-Үүл, Д. Батбилэг, Б. Галсандорж, И. Жавхлант, З. Эрдэнэбат, Б. Батцэнгэл, Г. Бошигт, Д. Дорлигжав, Д. Нинж, Д. Энхбаатар) Сүхбаатарын талбайд _____ зарлан тэмцжээ.
- 2) _____-ийг цорын ганц зөв онол хэмээн тулгаж, сэтгэлгээний эрх чөлөө, олон ургальч үзлийг хаан боогдуулж байв.
- 3) Монголын түүхэнд анхны олон намын оролцоотой, _____ 1990 оны VII сарын 29-нд явагдсан юм.
- 4) Сэхээтэн залуучуудын дунд _____ зэрэг нууц бүлгэмүүд байгуулагдаж, үйл ажиллагаа явуулах болов.
- 5) М. С. Горбачёв улс орондоо _____ өөрчлөн байгуулалт хэмээх нэрийн дор цогц шинэчлэлийг зарлан тунхаглажээ.
- 6) 1990-ээд оны Монголын түүхэн дэх нэг чухал үйл явдал бол 1992 оны I сарын 13-нд шинэ _____-ийг батлан гаргасан явдал бөгөөд энэ нь Монгол Улсад өнөөгийн ардчилсан эрх зүйт тогтолцоо бүрэлдэн төлөвших үндэс болсон юм.
- 7) 1990 оны II сарын 18-нд анхдугаар их хурал болж, тус хурлаар _____ эмхлэн байгуулснаа зарлав.
- 8) Ховд дахь Багшийн Дээд сургуулийн хэсэг залуу багш, оюутнууд Монголд анх удаа олон нийтийг хамарсан _____ зохион байгууллаа.
- 9) Эрх баригчдын болон ардчилсан хүчний төлөөллийн хооронд болсон уулзалт ярилцлагын үр дүнд талууд зарчмын тохиролцоонд хүрч _____ гаргав.
- 10) 1990 оны III сарын 22-24-нд хуралдсан АИХ-ын чуулган, МАХН бол “төр нийгмийг удирдан чиглүүлэх цорын ганц хүчин мөн” гэсэн 1960 оны Үндсэн хуулийн заалтыг хүчингүй болгосноор _____ эцэс болов.

В. 1990 оны ардчилсан хувьсгалын ач холбогдлыг тунгаан бодож, жагсаан бичнэ үү?


I	II	III
---	----	-----

4. Дасгал, даалгавар



Түүхэн зургуудад буй түүхэн зүтгэлтнүүдийн намтар, улс төрийн үйл ажиллагаа, Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар юу мэдэх вэ?



Би монгол хүний саруул ухаанд итгэдэг.  С.Зориг

Ж. Батмөнх	С. Зориг
Намтар:	Намтар:
Улс төрийн үйл ажиллагаа:	Улс төрийн үйл ажиллагаа
Гүйцэтгэсэн үүрэг:	Гүйцэтгэсэн үүрэг:

5. Дасгал, даалгавар



А. Социалист болон ардчилсан нийгмийн ялгаатай шинжүүдийг доор үзүүлэлтийн дагуу харьцуулна уу.

№	Гол шинж	Социалист нийгэм	Ардчилсан нийгэм
1	Өмч		
2	Үзэл суртал		
3	Хүний эрх		
4	Эдийн засаг		

В. Социалист нийгэм болон ардчилсан нийгмийн давуу болон сул талуудыг тодорхойлно уу.


Социалист нийгэм		Ардчилсан нийгэм	
Давуу тал:	Сул тал:	Давуу тал:	Сул тал:

6. Бие дааж ажиллах дасгал, даалгавар
 А. Сурвалжуудын мэдээ болон өөрийн мэдлэгт үндэслэн даалгаврыг гүйцэтгэнэ үү?


Сурвалж 1. Монгол Улсын Үндсэн хуулиас

“Монгол улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”

Сурвалж 2. Өмч хувьчлалын цэнхэр тасалбар



Сурвалж 3. Засгийн газрын 20-р тогтоол



Сурвалж 4. Картын барааны үеийн талон



Зах зээлийн эдийн засагт зайлшгүй шилжих шаардлага юу вэ?

Өмч хувьчлах арга хэмжээг хэзээ, ямар хэлбэрээр зохион байгуулсан бэ?

Цэнхэр болон ягаан тасалбараар юу юуг хэрхэн хувьчилсан бэ?

Засгийн газрын 20-р тогтоолыг гаргасны зорилго юу байсан бэ?


Яагаад хүнсийг картаар олгох болсон бэ?

В. Эдийн засгийн хүрээнд гарсан өөрчлөлтүүдийн шалтгаан, үр дагаврыг тодорхойлно уу.



№	Гол өөрчлөлт	Шалтгаан	Үр дагавар
1	Өмч хувьчлал		
2	Үнэ чөлөөлсөн		
3	Банкны шинэчлэл		

С. Сурвалжийн мэдээнд тулгуурлан дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.



Сурвалж 1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиас. (1998.08.28)


“Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглох, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт үл тогтоох, төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглох...”

Сурвалж 1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 1.1.6 дахь заалт

“Үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн”

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнгөрсөн, одоо, ирээдүйг тодорхой үндэслэл гаргаж уялдаа холбоонд тайлбарлана уу.

Ардчилсан нийгэмд шилжсэнээр оюун санааны амьдралд гарсан өөрчлөлтүүдийг тодорхой жишээ, баримтад (3-4) үндэслэн тайлбарлана уу.



Жишээ, Баримт 1	<hr/> <hr/> <hr/> <hr/>
Жишээ, Баримт 2	<hr/> <hr/> <hr/> <hr/>
Жишээ, Баримт 3	<hr/> <hr/> <hr/> <hr/>
Жишээ, Баримт 4	<hr/> <hr/> <hr/> <hr/>